



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/160

Эрдэнэбулган сум

Аймгийн 2023 оны Авлигын эсрэг
үйл ажиллагааны төлөвлөгөөг
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 дүгээр тогтоол, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх 2023 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ж.Мөнхбат)-т зөвшөөрсүгэй.
3. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Наранчимэг)-д үүрэг болгосугай.
4. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайланг хагас, бүтэн жилээр гарган ирүүлэхийг сумдын Засаг дарга, агентлаг, байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Алтангэрэл)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД

6513910447

Аймгийн Засаг даргын 2023 оны
 4/160 дугаар сарын 31-ны өдрийн
 дугаар захирамжийн хавсралт



АРХАНГАЙ АЙМГИЙН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Эрдэнэбулган сум

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.	1.1 АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	Жилийн турш	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)	Сум, агентлаг
		1.2 Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	Жилийн турш	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг
		1.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	Жилийн турш	Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг
		1.4 Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад	Жилийн турш	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;	Сум, агентлаг

		чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.		-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; -Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.	
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах.	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;	Жилийн турш	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг
		2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	Жилийн турш	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	Жилийн турш	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн	Сум, агентлаг

				төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	
		3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	Жилийн турш	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.	Сум, агентлаг
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	Жилийн турш	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх;	Сум, агентлаг
		4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;	Жилийн турш	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Сум, агентлаг
		4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	Жилийн турш	-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Сум, агентлаг
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан	Жилийн турш	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; -Арга хэмжээнд албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Тайланд нотломжийг	Сум, агентлаг

	хаагчдадаа танилцуулах;		хавсаргасан байх.	
	5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	Жилийн турш	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг
	5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах;	Жилийн турш	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -Тайлагнасан байх.	Сум, агентлаг
	5.3.1 Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, шийдвэрийг чанд мөрдөн ажиллах, сум орон нутгийнхаа хэмжээнд шударга, хариуцлагатай ил тод нийтийн албыг бэхжүүлэх;	Жилийн турш	-хууль бус томилгоо хийхгүй байх -сахилга, ёс зүйн зөрчилгүй ажиллах -төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байх	Сум, агентлаг
	5.3.2 Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлтэй хамтран ажиллах;	Жилийн турш	-Хамтран ажиллаж ажил, арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх. -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг
	5.3.3 Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулахаар бэлтгэгдсэн сургагч багш нартай хамтран сум, байгууллагынхаа нийт албан хаагч, иргэдийг хамруулан сургалт зохион байгуулах;	Жилийн турш	-Сургагч багш нартай хамтран сургалт зохион байгуулсан байх; -Сум, байгууллагын нийт албан хаагч, иргэдийг хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг
	5.3.4 Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх;	Жилийн турш	-Холбогдох арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгсөн байх. -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Сум, агентлаг

	5.3.5 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, үндэслэл бүхий хариу өгөх ажлыг сайжруулах;	Жилийн турш	-Өргөдөл, гомдлын хариуг хугацаанд өгсөн байх -Шийдвэрлэлт хуулийн дагуу, үндэслэлтэй байх. -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Сум, агентлаг
	5.3.6 Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан дүгнэлтийг нийтэд мэдээлэх;	Жилийн турш	-Олон нийтийн зүгээс танилцах боломжоор хангасан байх -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Сум, агентлаг
	5.3.7 Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэх;	Жилийн турш	-Хариуцлага хүлээлгэсэн байх -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Сум, агентлаг

---oOo---